

## УВС АЙМГИЙН ИТХ, ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2017 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Аймгийн ИТХ нь өөрийн гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлт, баталсан хөтөлбөр, үндсэн чиглэлийнхээ хэрэгжилтэд хяналт тавьж, аймгийн ИТХ-ын 2016-2020 оны үйл ажиллагаандаа мөрдөх үндсэн журмуудыг хэрэгжүүлэн, Хороод нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Мөн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийн биелэлтийг дүгнэж, 2018 оны үндсэн чиглэл, аймгийн 2018 оны төсөв, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг баталлаа.

### НЭГ. АЙМГИЙН ИТХ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



Аймгийн ИТХ-ын 2017 оны ажлын тайлангийн тухай видеог <https://www.facebook.com/uvskhural/videos/1917665375218555/>-ээр орж танилцана уу.

2017 онд аймгийн ИТХ-аас иргэдийн санал хүсэлт, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан дараах 3 зорилтыг дэвшүүлж тодорхой арга хэмжээг авч ажил хэрэг болгон ажиллалаа. Үүнд: нэгдүгээрт **Боловсролын салбарт гарааны үнэлгээ хийв.** Боловсролын салбарын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, сурагчдын мэдлэгийн түвшинг үнэлэх, гарааны үнэлгээг Аймгийн ИТХ-ын нэрэмжит болгон бүх шатны төлөөлөгчдийн оролцоотойгоор хичээлийн жилийн 2 болон 4 дүгээр улиралд зохион байгуулсны үр дүнд гарааны үнэлгээний стандарт хангалт 41,5 байсан бол 2017-2018 оны хичээлийн жилийн 2-р улиралд авсан шалгалтын дүнгээр 51,1 болж 9,6 хувиар дээшилсэн байна.

Аймгийн БСУГ-аас 2017 оны нэгдүгээр улиралд ЕБС-30, Цэцэрлэг-31, Соёлын төв-19, Хөгжимт жүжгийн театр, Музей, Төв номын сангийн үйл ажиллагаанд үр дүнд суурилсан боловсролын чанарыг сайжруулах хяналт үнэлгээг хийхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, нэгдсэн дүнг 2017 оны 04-р сарын 21-ны өдөр ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн Засаг дарга болон БСУГ-ын дарга нарт “Боловсрол, соёлын үйлчилгээ, чанарыг сайжруулах тухай” А/48-тоот албан бичгийг хүргүүлэн хариуг 2017 оны 06-р сарын 28-ны өдөр авч дүгнэлт хийж ажиллалаа.

Мөн 2-р улиралд зохион байгуулагдсан анги нийтийн олимпиадын дүнг нэгтгэн сурагчдын сургалтын чанар, хүүхэд нэг бүрийн сурлагын түвшин үнэлэх үзүүлэлтэд тусгасан.

3-р улиралд аймгийн ИТХ-ын ажлын албаны мэргэжилтнүүд, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн хамт хөдөө сумдын ИТХ-ын үйл ажиллагаанд 5 хэсэг болон үнэлгээ хийж, аймгийн ИТХ-ын 2017 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/12 тоот тогтоолоор батлагдсан аймгийн “Монгол хэл, бичиг” болон 2017 оны 03 сарын 12 өдрийн А/22 тоот тогтоолоор батлагдсан Увс аймгийн “Боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцтай танилцаж, сургуулийн багш ажилчид, эцэг эх, иргэд хөдөлмөрчдийн дунд уулзалт зохион байгуулж, 2 төрлийн сэтгэл ханамжийн судалгаа авлаа.

Мөн 4 дүгээр улиралд аймгийн БСУГ-т чиглэл өгч аймгийн ЕБС-ын сурагчдын сурлагын чанар, стандарт үнэлгээ өгөх хоёр дахь шатны шалгалтыг мөн сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарын оролцоотойгоор зохион байгуулж дүнг мэргэжлийн байгууллага нэгтгэн гаргалаа.

Боловсролын багц хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХ-аас 738 хүнийг хамруулан судалгаа хийхэд ЕБС-ийн хүүхдүүдээс мэдлэгийн түвшин тогтоох хөндлөнгийн шалгалтыг авч байх зөв зүйтэй ажил гэж судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын 8 нь буюу **81,8%** нь үзлээ.

## БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР

	Аймгийн төв/ Улаангом сумын иргэд	Хөдөө сумын иргэд
<b>ХОЁР</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Цэцэрлэг, сургуулийн тоог нэмэгдүүлж, нэг ангид суралцах хүүхдийн тоог стандартад хүргэх</li> <li>2. Багш нарын мэдлэг чадварыг сайжруулах замаар сурагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх</li> <li>3. Хүүхдэд физик, хими гэж заахаас гадна сурагчдын ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, эх оронч үзлийг бүрдүүлэх, хүн хүнээ хайрлах, хүндлэх ёсонд сургах хэрэгтэй</li> <li>4. Сурах бичгийн хүрэлцээг нэмэгдүүлж хангалтыг сайжруулах</li> <li>5. Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлсэн ажил зохион байгуулах</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш нарын мэдлэг, ур чадварыг үнэлэх, сайжруулах замаар сурагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх, багш нарыг нам, улс төрөөс ангид байлгах</li> <li>2. Хүүхдийн сурч боловсрол таатай орчин бүрдүүлэх, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, дотроо нойлын өрөөтэй болох, камержуулах, дотуур байр, спорт заалуудад анхаарах</li> <li>3. Сургуулийг өндөр хурдны интернет, шилэн кабельд холбох</li> <li>4. Сурах бичгийн хүрэлцээг нэмэгдүүлж хангалтыг сайжруулах</li> <li>5. Нэгдсэн халаалтыг шуурхай зохион байгуулж холбох</li> </ol>

Бид жил бүр энэхүү судалгааг тогтмол авч нэгтгэн дүгнэж төрийн бодлого шийдвэрт тусгаж байхыг хүссэн иргэдийн хүсэлт, Боловсролын багц хөтөлбөрийн хүрээнд дээрх үнэлгээг жил бүр хийж, нийт хүүхдийн сурлагын чанарт тууштай анхаарч, Увс аймгийн хөгжлийн түлхүүр болсон өндөр мэдлэг, чадвартай сурагч ирээдүй хойч үеийг бэлтгэн гаргахад аймгийн ИТХ-аас цаашид байнга анхаарч ажиллах юм.

**Хоёрдугаарт: Иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд анхаарал хандуулж** аймгийн ИТХ-ын хуралдаанаар “Баг-83” үйл ажиллагаанд төсвийн тодотголд тусгахаар хурлын төлөөлөгчид санаачлага гарган дэмжиж уг үйл ажиллагааг зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллалаа. Бэлгийн замын халдварт өвчний тархалт их байгаа нь илэрч, хавдрын эрт илрүүлэг нэмэгдлээ. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч 870 хүнээр нэмэгдсэн. 22078 хүнд лабораторийн үзлэг хийгдэж, зүрхний эхо, эхо зэрэг үзлэг оношлогоо 30000 тохиолдлоор нэмэгдсэн. 1-5 насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдлоор буурсан. Умайн гаднах жирэмслэлт, олгой, цөсийг дурангаар авч байна. Тархины тодосгогчидтой шинжилгээ хийж компьютер оношлогоогоор хавдрыг илрүүллээ.

**Гуравдугаарт. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, архидалтгүй төрийн алба буй болгохыг зорьж ажиллалаа.**

2017 оныг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг таслан зогсоох зорилт дэвшүүлэн аймгийн Цагдаагийн газарт 3 ширхэг согтуурал хэмжигч багажийг 1,785,000 төгрөгөөр, бэлэн бус торгуулийн машины 2,497,000 төгрөгөөр тус тус шийдвэрлэн өгч ажиллалаа. Ингэснээр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэмт хэргийн зөрчил ноднин жилийн мөн үетэй харьцуулахад **254** болж **16,7%**-иар буурсан үзүүлэлттэй байна.

Мөн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэй аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг УБ хотод манлайллын тухай сургалтад хамруулж аймгийн ИТХ-ын зарим төлөөлөгчдийг ОХУ-ын Тува улсад явуулж, зарим төлөөлөгчдийг хөнгөлттэй нөхцөлтэйгээр буюу 2.5 сая төгрөгийг өөрөөсөө гаргаж

үлдсэн 2.5 сая төгрөгийг нь Солонгосын талаас гаргуулж 6 төлөөлөгч БНСУ-д яваад ирлээ.

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтарсан төслийн хүрээнд сургагч багш нарыг бэлтгэж, багийн ИНХ-ийн дарга нарын сургалтыг зохион байгууллаа. Баян-Өлгий аймгийн Багийн ИНХ-ийн дарга нарын сургалтад манай аймгийн сургагч багш ажиллалаа. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг “Манлайлал”-ын чиглэлээр УИХ-ын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд УБ-хотод сургалтад хамрууллаа.

Дээрх төслийн хүрээнд аймгийн ИТХ-ын ажлын албанаас 2 мэргэжилтэн УБ-хотод сургагч багшаар бэлтгэгдэж, бүх сумдын багийн ИНХ-ын дарга нарыг сумын ИТХ-ын дарга нарын хамт сургалтад хамрууллаа. Уг сургалтад 93 багийн ИНХ-ын дарга нар хамрагдах ёстойгоос 3 хүн эрүүл мэндийн шалтгаанаар оролцож чадаагүй ч ирц өндөр, цаг үеэ олсон сургалт боллоо хэмээн үзэж байна.

Мөн нэмэлт санхүүжилтээр “Монгол Улсын Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн **20,1** сая төгрөгийн санхүүжилт бүхий сургалтыг зохион байгуулсан. Улсын Их Хурлын Тамгын газраас **5** сая төгрөгний санхүүжилт хийгдэж Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэг, Швейцарийн хөгжлийн агентлагт “Боловсролынхоо чанарыг мэдье-Бодлогоо зөв тодорхойлъя” төсөл бичиж **4** сая төгрөгийн санхүүжилт авч тус тусын үйл ажиллагаанд нь зарцууллаа.

Монгол улсын бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдсэн портал “хурал.мн” цахим сайтад мэдээ байршуулах сургалтыг ажлын албанаас зохион байгуулснаар иргэд олон нийтэд энэхүү сайтаар хүрэх мэдээллийн тоо өсөж 2017 онд аймгийн ИТХ-ын сайтаар 144 мэдээлэл нийтийн хүртээл болсон.

УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд бүтээгдсэн [www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудасны дэд цахим хуудсыг хөгжүүлэх уралдаанд 3-р байр эзэлж 500000 төг-өөр шагнууллаа.

Сумдаас Ховд, Сагил, Түргэн, Хяргас, Зүүнговь, Завхан, Өмнөговь сумууд мэдээ мэдээллээ шуурхай тавьж хэвшээд байна.

Аймгийн ИТХ нь 2017 онд **86** ажил, арга хэмжээг төлөвлөснөөс **81** ажил арга хэмжээг хэрэгжүүлэн зохион байгуулж өнөөгийн байдлаар төлөвлөгөөт ажил **93,7%**-иар биелэв.

Аймгийн ИТХурал, ажлын алба нь 2017 онд 10 орон тоотойгоор 368.9 сая төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Төсвийг задаргаагаар нь тайлбарлавал 27% нь ажлын албаны ажилчдын цалин, 3% НДШимтгэл, 2,8% нь дотоод томилолт, 4,6% нь тээвэр шатахууны зардал, 0,9% нь бичиг хэрэгт, 1,08% нь шуудан холбоо, 0,9% бага үнэтэй түргэн элэгдэх зардалд, 3,9% нь хуралдааны зардал, 0,8% нь мэдээлэл сурталчилгааны зардал, 9,8% нь нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд, 6,7% нь ГХУСАЗЗөвлөлийн зардал, 9,1% нь Багаж техник хэрэгслийн зардал, 6,2% урсгал засварын зардал, 0,8% нь бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардал, 22,4% нь төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардалд тус бүр төсөвлөж үйл ажиллагааны дагуу зарцуулагдаж байна.

Иргэдээс авсан судалгааны санал асуулгын хэсэгт давхардсан тоогоор нийт **959** санал ирснийг утга агуулгын хувьд эрэмбэлж эхний 5 саналыг гаргахад: Дараах байдалтай байна. Үүнд:

## АЙМАГ ОРОН НУТГИЙН БОДЛОГО ШИЙДВЭРИЙН ТАЛААР

Аймгийн төв/ Улаангом сумын иргэд


Хөдөө сумдын иргэд

## НЭГ

1. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажилгүйдлийг бууруулах
2. Эмзэг бүлгийнхнийг дэмжих ялангуяа залуучуудад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх
3. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих
4. Сум, багийн түвшинд үйлдвэрлэл бий болгох
5. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг сайжруулж, хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажиллах

1. Сумдын онцлогтой холбогдуулан ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажилгүйдлийг багасгах замаар иргэдийн орлоготой болгож ядуурлыг бууруулах
2. Эмзэг бүлгийнхнийг дэмжих ялангуяа залуучуудад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх
3. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих
4. Отор нүүдлийн асуудлыг зохицуулж гүний худаг барих замаар бэлчээрийн хүртээмжийг нэмэгдүүлэх
5. Шаардлага хангасан стандартын халуун устай болох

Монгол улсад НӨУБ үүсч хөгжсөний 25 жилийн ойг Увс аймагт тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн ИТХ-аас ажлын төлөвлөгөө гарган ажиллаж Аймгийн ИТХ-ын үе үеийн дарга, нарийн бичгийн дарга нарын телевизийн хөрөг нэвтрүүлгийг хийж, 1992 оноос хойшхи Увс аймгийн ИТХ-ын түүхийг багцлан харуулсан 90 гаруй хуудастай “Увс аймгийн ИТХ-ын түүхэн товчоо-1992-2017” номыг 500 хувь хэвлүүлэн гаргалаа.



<https://www.youtube.com/watch?v=rbeKcaqGKmc> болон

<https://www.youtube.com/watch?v=S31aOFN9whk> холбоосоор үзнэ үү.

Энэхүү бүтээлүүдээрээ Увс аймгийн ИТХ-ын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах ИТХ-ын үе үеийн дарга,

төлөөлөгчид, ажлын албанд ажиллаж байсан мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг хойч үедээ үлдээх зорилготой юм.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар болон 93 багийн ИТХ-ын дарга, Улаангом сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн дунд уулзалт, сургалт, спортын нөхөрсөг тэмцээнийг 2 үе шаттайгаар зохион байгуулав.

“Гар бөмбөг”-ийн тэмцээний 1-р байрыг аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн баг, 2-р байрыг Улаангом сумын ИТХ-ын төлөөлөгчдийн баг, 3-р байрыг сумдын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын баг тус тус эзэллээ.

Мөн тус ойн хүрээнд НӨУБ-ын мөрдөж буй хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, цаашид шаардлагатай байгаа өөрчлөлт шинэчлэлтийн хэрэгцээг тодорхойлох, орон нутгийн хөгжилд нутгийн өөрөө удирдах байгууллагын оруулах хувь нэмрийг судлаж боловсронгуй болгох зорилгоор “Онол практик”-ийн хурал, илтгэлийн уралдаан зохион байгууллаа. Дээрх уралдаанд 11 илтгэл ирснээс хоёр дахь шатанд 7 илтгэлийг нь шалгаруулан тэмцээнийг зохион байгуулахад Өмнөговь сумын ИТХ-ын дарга Б.Цэрэнпил, Улаангом сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн НБДарга Ж.Очирбат, Давст сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн НБДарга Б.Ичинхорлоо нарын илтгэл эхний 3 байрыг эзэллээ.

Орон нутгийн өмчид 225,9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа ба хөрөнгийн тайлан мэдээнд онлайнаар хяналт тавьж байна.



Орон нутгийн өмч хөрөнгийн бүртгэлийг сайжруулах зорилгоор барилга байгууламж ашиглалтад хүлээж авах 8 удаагийн улсын комисст орж ажиллан улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 10,7 тэрбум төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчийн бүртгэлд тусгууллаа.

2016 оны хөрөнгийн тооллоготой холбоотой дутагдуулсан, маргаантай, бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчил дутагдлын мөрөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид хариуцлага тооцлоо. Хүнсний худалдааны “Мини зах”-ын хувьчлалын гэрээг цуцлах аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр гарч, хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Орон нутгийн өмчит байгууллагуудаас ирүүлсэн актлах, худалдах, балансаас балансад шилжүүлэх хөрөнгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 7 удаагийн хуралдаанаар хэлэлцэн 2017 онд 10 байгууллагын нийт 210110,5 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 15 ширхэг, 38127,5 мянган төгрөгийн худалдах доод үнэ бүхий хөрөнгийг 8 удаагийн дуудлагаар худалдаж 33240,0 мянган төгрөг, илүүдэлтэй хөрөнгийг иргэн аж ахуйн нэгжүүдэд түрээслэн 2017 онд 18001,6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. 15 байгууллагын нийт 280246,2 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 554 ширхэг хөрөнгийг актлахаар, 7 байгууллагын нийт 151537,6 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 56 ширхэг хөрөнгийг орон нутгийн өмчит 21 байгууллагад балансаас балансад шилжүүлсэн. 2017 онд ОНӨС-д хөрөнгө худалдсаны орлого- 33,24 сая төгрөг, түрээсийн орлого -18 сая төгрөг, хувьчлалын орлого- 70,2 сая төгрөг нийт 121,4 сая төгрөг төвлөрүүлж хувьчлалын орлого хассан дүнгээр орлогын төлөвлөгөөг 146,4 хувьтай биелүүллээ.

Улсын их хурлын Тамгын газраас зохион байгуулсан МУ-ын Үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг зохион байгуулж аймгийн хэмжээнд 3 бүсэд УИХ-ын Аюулгүй байдлын байнгын хорооны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэнгээр ахлуулсан баг, УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар, Н.Цэрэнбат нартай хамтран зохион байгуулж, сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж аймгийн 93 багт дээрх хэлэлцүүлгийг зохион байгуулж **5100** хүний саналыг авч УИХ-ын Тамгын газарт хүлээлгэн өглөө.

#### **Сумдын ИТХ-ын ажлын талаар:**

Аймгийн 19 сумдын ИТХ-ын хуралдаан 49 удаа хуралдаж 275 асуудал хэлэлцэж 978 заалт бүхий 283 тогтоол гаргаж, 3 дэд хөтөлбөр, 1 төлөвлөгөө баталсан байна.

Тэргүүлэгчдийн хурал 256 удаа хуралдаж, 975 асуудал хэлэлцэж 2345 заалт бүхий 1028 тогтоол, 9 журам гарган хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Хурлын хороод 55 удаа хуралдаж, 66 санал дүгнэлт гаргаж, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажил, үйлчилгээ, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт зэрэгт 220 удаа хяналт шалгалт хийж 584 хүн хамрагдаж 35 зөвлөмж өгч ажилласан байна.

Багийн ИНХ 274 удаа хуралдаж 23684 иргэн оролцож, иргэдийн дунд 64 хэлэлцүүлэг, 131 удаа санал асуулга явуулж 31464 иргэн оролцож 249 санал, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэлээ.

2017 оны ажлын дүнг үндэслэж аймгийн ИТХ-ын шилдэг төлөөлөгчөөр Г.Цэрэндулам, С.Анхбаяр, Б.Алтанчулуун, С.Бямбабаатар, Б.Батмөнх, Өндөрхангай, Зүүнговь, Ховд сумын ИТХ-ыг тус тус шалгаруулж аймгийн ИТХ-ын Хүндэт медальон, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүд болон аймгийн ИТХ-ын ажлын албаны мэргэжилтнүүд харилцан мэдээлэл солилцох, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэх үүднээс сар бүр тогтсон өдөр уулзаж цаг үеийн асуудлаар ярилцлага зохион байгуулж эхэллээ.

Гадаадын хөрөнгө оруулагч, төсөл хөтөлбөрийн газруудтай холбоо тогтоох, хамтран ажиллах талаар аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нар нягт идэвхтэй ажилласнаар 2017 онд эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын засварын ажлуудын хөрөнгийг шийдвэрлүүлсэн.

Аймгийн ИТХ-ын хороод ЗДТГ-ын хэлтэс, агентлагийн дарга нарын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны зорилтод **26** төлөөлөгч нийт **198** санал ирүүлснийг аймгийн ИТХ-ын ажлын албанаас аймгийн Засаг дарга болон холбогдох хэлтэст хүргүүлж төсвийн боломжоос хамааран оны зорилтонд 41% нь тусгагдлаа.

## **ХОЁР. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААН**

Аймгийн ИТХ-ын хуралдааныг 2017 онд 2 удаа хуралдсан ба аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн 5-р хуралдаан 2017 оны 5-р сарын 30-ны өдөр хуралдаж аймгийн төсвийн тодотгол болон зөвлөлийн ажиллах журам батлах тухай 17 заалт 2 тогтоол баталлаа.

Аймгийн ИТХ-ын 6-р хуралдаан 2017 оны 12-р сарын 4-6-ны өдрүүдэд хуралдаж

1. Аймгийн 2017 оны төсөвт тодотгол хийх тухай
2. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт
3. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийг батлах
4. Аймгийн 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2018 оны төсвийг батлах
5. Аймгийн ИТХ-ын 2017 оны ажлын тайлан
6. а. Аймгийн 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах  
б. Газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах
7. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол оруулах тухай
8. Увс аймагт аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөр баталсан хуралдааны тогтоол хүчингүйд тооцох тухай
9. Увс аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
10. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчийг чөлөөлж, сонгох тухай гэсэн асуудлуудыг хэлэлцэж 62 заалт бүхий 12 тогтоол баталлаа.

Хуралдаанаар нийт 104 санал шүүмжлэл, Хурлын хороо, сумдад хяналт шинжилгээ үнэлгээ хийх үед гарсан саналыг Аймгийн засаг дарга болон Боловсрол соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Улаангом сумын засаг дарга болон холбогдох бусад байгууллагуудад тухай бүрд нь багцлан хүргүүлж, хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтан зохион байгуулж, хурлын ажлын албаны зүгээс биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Увс аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай журмыг хуралдаанаар 2 удаа хэлэлцэж Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэн мөрдөж эхэллээ.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардалд 82 сая төгрөг зарцууллаа. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгч Д.Мягмарсүрэн аймгийн Засаг даргын зөвлөхөөр ажиллах болсон тул тэргүүлэгчээс чөлөөлсөн. ИТХ-ын тэргүүлэгчдэд 3,6 сая төг, иргэний зөвлөлд 1,4 сая төг-ийн урамшуулал олгож ажиллах нөхцөлийг нь хангаж өглөө.

## **ГУРАВ. ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал нийт 16 удаа хуралдаж 87 асуудал хэлэлцэж 91 заалт бүхий 58 тогтоол, 27 тэмдэглэл гаргаж, аймгийн салбар бүрт хэрэгжих Боловсролыг хөгжүүлэх, Монгол хэл бичиг, Аялал жуулчлалыг хөгжүүлэх,

“Зоорь”, “Хүлэмж”, “Элэг бүтэн Увс”, “Төсвийн сахилга бат”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” гэх мэт дунд хугацааны хөтөлбөрүүдийг баталж, Улсын сайн малчин, тэргүүний тариаланчид тодорхойлох, ой тэмдэглэн өнгөрүүлэх тов тогтоох, нэрэмжит болгон алдаршуулах, ОНӨААТҮГ-уудын тайланг хэлэлцэж хэрэгжилтийг нь хангуулах зэрэг чухал асуудлуудаас гадна өвөлжилтийн бэлтгэл хангах, дулааны шугам сүлжээний холболтын талаар болон албан байгууллагуудын үйл ажиллагааны явцын мэдээллийг хэлэлцэн үүрэг чиглэл өгөх зэрэг цаг үеийн олон асуудлыг шуурхай хэлэлцэн ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид энэ онд тухайн тойргийн сумдын Багийн иргэдийн нийтийн хуралд оролцож иргэд сонгогчдынхоо санал хүсэлтийг сонсож, төрийн бодлого шийдвэрийг тайлбарлан сурталчлахаас гадна МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн уулзалтыг зохион байгуулах, Ханхөхий хайрханы тэнгэрийг тайх ёслол, Баруун бүсийн хурдан морины уралдааны зохион байгуулалтад оролцох, тойргийн сум, багтаа Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг аймаг орон нутгийн цаг үеийн төлөвлөгөөт томоохон ажлуудад идэвхтэй оролцлоо.

Мөн тойргийн сумын ИТХ-ын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, тухайн сумдын ЕБС-ийн үйл ажиллагаа, Боловсролын багц хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах, багш ажилчид, эцэг эхчүүдийн уулзалт хийж хэлэлцүүлэг зохион байгуулах, сэтгэл ханамжийн судалгаа авах ажлуудад идэвх санаачлага гарган ажиллалаа.

## **ДӨРӨВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ**

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн ИТХ-ын захиалгаар Үндэсний аудитын харьяа Увс аймгийн аудитын газраар жилд 3 хүртэлх гүйцэтгэл, нийцлийн аудит хийлгэж, тайлан, дүн мэдээг хүлээн авч хороод, хурлын төлөөлөгчдөд хүргүүлээд байна.

Аймгийн ИТХ-ын Хууль эрх зүй, дотоод хяналтын хорооны бүрэлдэхүүн аймгийн Прокурорын газар, Тагнуулын газар, Цагдаагийн газар, аймгийн Шүүхийн тамгын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүх шинжилгээний алба, ХЦ-ийн 0245-р анги, Гадаадын иргэний харьяатын асуудал эрхлэх газар, Татварын хэлтэс, Гаалийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс, Онцгой байдлын газар, Улсын бүртгэлийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс зэрэг газруудаар удирдамжийн хүрээнд ажиллаж тухайн байгууллагын ажил байдалтай нь танилцаж, хорооны хурлаар хэлэлцэн зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Мөн аймгийн ИТХ-ын Төсөв, санхүү эдийн засгийн хөгжлийн болон Байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлын хороо удирдамжийн дагуу аймгийн “Дулааны хоёрдугаар станц, дулааны шугам сүлжээ” ОНӨААТҮГ, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст ажиллаж тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны эмх цэгц, тулгамдаж буй асуудал, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, төсөв санхүүгийн ил тод байдалд үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын Хүний хөгжил, нийгмийн асуудлын хорооны бүрэлдэхүүн Улаангом сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төвүүд, Сургууль, Цэцэрлэгүүд, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Музей, Номын сан, Ойрад Хөгжимт жүжгийн театр, Биеийн тамир спортын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газруудаар явж ажиллалаа.

Мөн аймгийн ИТХ-ын 2017 оны онцлох ажлын нэг болон ЕБС-ийн сурагчдын мэдлэгийн түвшинд үнэлгээ хийх шалгалт явц, аймгийн БСУГ-ын мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийж хамтран ажиллалаа.

Тува улсын дээд хурал Увс аймгийн ИТХ хамтран зохион байгуулж хэвшсэн Орос хэлний багш нарын заах аргазүйн сургалт, сурагчдын дундах уралдааныг Тува улсын дээд хурал, Боловсролын Шинжлэх ухааны сайдын орлогч болон бусад мэргэжилтнүүдтэй хамтран амжилттай зохион байгууллаа.

Уг хорооны бүрэлдэхүүн нь сумдын ИТХ-ын дэргэд ажиллаж байсан иргэний танхимын ажилтны ажлын байрны хэрэгцээ, шаардлагыг судлах, сумдын ИТХ-ын хөдөлмөрийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор бүсийн сумдаас

түүвэрлэн авч аймгийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд хамтран баг болж ажиллалаа. Ингэснээр сумын ЗДТГ-ын хууль эрх зүй, дотоод хэргийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод зарим чиг үүргийг тусгуулан ажиллахаар боллоо.

Аймгийн ИТХ-ын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссаны дагуу ИТХ-аас гарч буй шийдвэрүүдэд иргэд хөдөлмөрчид, аж ахуйн нэгжийн санал хүсэлтийг тусгаж, хурлаас гарсан тогтоол шийдвэрийг олон нийтэд хүргэхэд төлөөлөгчдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хурлын хороодын дунд болзолт уралдааныг зарлаж удирдамжийн дагуу үйл ажиллагааг нь үнэлж, дүгнэн ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сумдын ИТХ-ын үйл ажиллагаанд хурлын төлөөлөгч, ажлын албаны мэргэжилтнүүдийн хамтарсан баг хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Энэхүү үнэлгээгээр нийт сумдын ИТХ-ын үйл ажиллагаа дунджаар **69.4%-тай** байна.

Өндөрхангай, Зүүнговь, Ховд, Наранбулаг, Тариалан сумууд аймгийн дундаж үнэлгээ буюу 69,4%-иас дээш үнэлгээ авсан бол Зүүнхангай, Баруунтуруун, Сагил, Давст, Өмнөговь, Тэс сумдын үйл ажиллагаа аймгийн дунджаас доогуур үнэлгээтэй байна.

## ТАВ. БУСАД АЖИЛ

2017 онд ГХУСАЗСЗ-өөс 8 бүлэг бүхий 37 ажил төлөвлөснөөс 30 ажлыг гүйцэтгэж 81%-ын биелэлттэй байна. Энэ жил ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүн, зорилт үйл ажиллагаа оновчтой төлөвлөж, шуурхай ажилласнаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэмт хэргийн зөрчил ноднин жилийн мөн үетэй харьцуулахад **254** болж **16,7%-иар** буурсан.



“Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт баруун бүсийн уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээлэл, телевизийн шторкыг бэлтгэх хуваарийн дагуу орон нутгийн телевизүүд болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилж ажиллалаа.

Мөн ГХУСАЗСЗ-өөс ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтэс, Прокурор, Цагдаагийн газрын хамтарсан удирдамжийн дагуу Тэс, Тариалан, Өндөрхангай, Зүүнхангай, Наранбулаг сумдын ГХУСА-тай танилцаж албан байгууллагуудын дотоод үйл ажиллагаануудад үнэлгээ өгч, ажилтан, албан хаагчдыг оролцуулсан хэлэлцүүлэг, зөрчлийн тухай болон гэр бүл, хүчирхийллийн тухай хууль, эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын талаар сургалт зохион байгуулж тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэлээ.



2017 оны ажлын төлөвлөгөөнд тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үүний дотор архи дан согтуурах болон мансуурах төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зарим сумдын цагдаа нарыг согтуурал хэмжигч хэрэгслээр хангахаар тусгагдсан. Энэ ажлын хүрээнд аймгийн ГХУСАЗСЗ-ийн дарга Э.Насанбат, зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Алтан, зөвлөлийн гишүүн, аймгийн ИТХ-ын ХЭЗДХХ дарга П.Баттулга нар согтуурал хэмжигч багаж 3 ширхэг драйгерийг аймгийн Цагдаагийн газарт хүлээлгэн өглөө.



ЕБС-ийн хүүхдүүдэд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох зорилго бүхий “Ногоон гэрэл-Цагаан шугам” тэмцээнийг холбогдох байгууллагууд зохион байгуулж аймгийн ГХУС салбар зөвлөлөөс санхүүжүүллээ.



Аймгийн ИТХ-аас зохион байгуулсан Баруун бүсийн аймгуудын Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтан, сонгуультан, ОХУ-ын Тува улсын Дээд хурлын төлөөллийн уулзалт хэлэлцүүлэг, спортын нэгдсэн арга хэмжээг удирдаж, хуваарийн дагуу зохион байгуулахад идэвх санаачлагатай оролцож амжилттай зохион байгууллаа.

МУ-ын Сонгуулийн Ерөнхий хорооноос өгсөн чиглэлийн дагуу аймгийн ИТХ-аас МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах хүний нөөцийг бүрдүүлэх сургалтыг аймгийн хэмжээнд 2 удаа зохион байгуулж МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн хорооны аймгийн салбар хороо байгуулагдахаас өмнөх бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллалаа.

Монголын нутгийн удирдлагын холбоо, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Архангай, Улаанбаатар хотын дүүргүүдийн ИТХ-ын ажлын албанаас мэргэжилтнүүд, Өвөрхангай аймгийн ИТХ-ын ажлын алба хүрэлцэн ирж хэлэлцүүлэг, харилцан туршлага судлах уулзалтыг зохион байгууллаа.

УИХ-ын дарга М.Энхболдын ивээл дор зохион байгуулагдсан шатар сонирхогчдын насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Аймаг орныхоо ирээдүй хойч үе болсон хүүхэд багачуудын сайн сайхны төлөө ажиллаж тэднийг хөгжүүлэх болон нийгэмд тустай олон сайн үйлс бүтээж 2017 оны ажил үйлсээрээ бусдыгаа манлайлсан Сагил сумын дунд сургуулийн “Сурагчдын зөвлөл”, Улаангом сумын Цогцолбор 1-р сургуулийн “Гоо даль”эко клуб, Улаангом сумын Ахлах 4-р сургуулийн “Өсвөрийн улаанзагалмайн бүлгэм”, Бөхмөрөн сумын дунд сургууль “Эко клуб” шилдэг хүүхдийн өөрөө удирдах байгууллагаар шалгарлаа.

Тогтоолуудын хэрэгжилтийг хангах зорилгоор хурлын даргын 25 захирамж, ажлын албаны даргын 28 тушаал гарснаас гадна аймгийн ИТХ-д Засгийн газрын албан тоот-25, тогтоол-21, ЗГ-ын тэмдэглэл-16, ЗГ-ын захирамж-8, УИХ-ын албан тоот-12, сум байгууллага, агентлаг, хэлтэс төрийн бус байгууллагын албан тоот-232, Ерөнхийлөгчийн Тамгын газрын албан тоот-6, Авилгатай тэмцэх газрын тоот-22, Сонгуулийн ерөнхий хорооны албан тоот-38, ЦАУЗБУКомиссын албан тоот-9, аймгийн Засаг даргын зөвлөлийн тэмдэглэл -12, сумын хурлаас- 38, Сумын сонгуулийн хорооноос- 10, Цагдаагийн хэлтсээс-17, Аудитын тайлан-14, албан тоот-5, Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөс-8, ГХУСАЗЗ-өөс 24, иргэдийн өргөдөл гомдол 21, НӨУБайгууллагаас-6, нийт **556** албан тоот ирснийг хүлээн авч судлан шийдвэрлэж ажиллалаа.

Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар ирүүлсэн аймгийн Засаг даргын зөвлөлийн саналыг хэлэлцэн Ардын зүтгэлтэн-1, Гавьяат зүтгэлтэн-18, Сүхбаатарын одонд-1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонд-33, Цэргийн гавьяаны одонд-4, Алтан гадас одонд-191, Хөдөлмөрийн хүндэт медальд-244, Цэргийн хүндэт медальд-2 нийт **494** хүнийг тодорхойлон шагнуулахаар Ерөнхийлөгчийн тамгын газарт уламжилснаас **32** хүний шагнал шийдвэрлэгдэж ирээд байна.

Сумдын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарт 2017 оны эхэнд аймгийн ИТХ-аас болон ГХУСАЗСЗ-өөс хийж хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагааг танилцуулах, хурлын дотоод ажил, цахим сайтад мэдээ мэдээллээ шуурхай байршуулах болон багийн ИНХ-уудыг зохион байгуулах талаар зөвлөмж, үүрэг чиглэл өгөх зорилгоор нэгдсэн сургалтыг аймгийн төвд 2 өдөр зохион байгууллаа.

Мөн Монголын нутгийн удирдлагын холбооноос зохион байгуулсан сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн сургалтад Бөхмөрөн, Түргэн, Улаангом сумууд хамрагдсан бол хурлын дарга нарын сургалтад бүх сумдын дарга нар 1 удаа, Нарийн бичгийн дарга нарын сургалтад бүх сумынхан 2 удаа Улаанбаатар хотод сургалтад хамрагдлаа.

Аймгийн ИТХ, хурлын хороодын үйл ажиллагааг орон нутгийн телевиз, Монгол улсын бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэгдсэн портал ХУРАЛ.МН цахим сайт, Увсын өнгө сониноор дамжуулан МОНЦАМЭ сайтад байршуулах замаар иргэдэд хурлын үйл ажиллагааг шуурхай хүргэсээр байна.

Энэ жил Увс Телевизээр 4, САМА телевизээр 20 удаа, МВС телевизээр 21 удаагийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэж, Тодруулга мэдээллийг 6 удаа өгсөн байна. Үүнээс гадна хурлын хуралдаануудыг тухай бүрт бүрэн эхээр олон нийтэд нээлттэй хүргэж байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын ажлыг хүрээнд нэхэмжлэгч Увс аймгийн Ховд сумын 1 дүгээр багт оршин суух Зөөд овогт Идэшийн Нэргүйгийн нэхэмжлэлийг хэлэлцэн холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрийн дагуу цагаатгалын нөхөн олговор болох 1000,000 төгрөгийг олгууллаа.

Мөн Бөхмөрөн сумын иргэн Баянцолын Түгжээгийн зээ охин Готовын Цогзолмаагийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч холбогдох баримтуудыг нягтлан ажиллаж байна. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн төрсөн болон албан ёсоор үрчилсэн хүүхдүүдийн судалгааг гарган аймгийн ЦАУЗБСК-ын 07 тоот албан бичгээр Улсын комисст хүргүүллээ. Дээрх судалгааны дүнгээр манай аймагт 11 хүн амьд сэрүүн байна. Мөн ЦАУЗБУК-оос шаардсан 2 судалгааг гаргаж цаг хугацаанд нь хүргэсэн байна. Энэ жил хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг бүх сумд зохион байгуулсан нь онцлогтой байлаа.

2. Аймаг, сумын ИТХ-ын нөхөн сонгууль 2017 онд явагдаагүй. Ховд сумын ИТХ-ын нэг төлөөлөгч нас барсан учраас 2018 онд нөхөн сонгууль явагдана. Наранбулаг сумын ИТХ-ын дарга Дашдэмбэрэл хангалтгүй ажилласан учраас чөлөөлж, Хурлын даргаар Ч.Сундуйжав сонгогдлоо. Зүүнхангай сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт 6 сарын хугацаатай үүрэг чиглэл өгсөн. Аймаг, сумын Хурлын шийдвэрт Засаг дарга хориг тавиагүй.

3. Цаашид аймгийн ЦАУЗБУК-д ирж буй өргөдөл хүсэлтийн ихэнх нь мөнгөн тусламж, гэр, түлээ нүүрсний дэмжлэг авах тухай өгүүлсэн байна. Тиймээс Цагаатгалын хуулийн хүрээнд улсын төсвөөс тодорхой зардлыг тусгаж ажиллах нь зүйтэй байна.

Цаашид хурлын Тэргүүлэгч, Төлөөлөгч, хурлын Хороодыг хөдөө сум, баг, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүрч ажиллах боломжийг бүрдүүлэх, гүйцэтгэх байгууллагуудын үйл ажиллагааг газар дээр нь үнэлэх, тэдэнтэй хамтран ажиллахад гаргасан амжилт, арвин туршлагаа ахиулахаас гадна хөрш зэргэлдээх болон бусад улс орны ижил төрлийн байгууллагуудаас туршлага судлах, шинэ санаа, санаачлагыг нэвтрүүлэх ажлуудад анхаарлаа хандуулах шаардлага тулгарч байна. Ингэснээр аймаг, сумдын ИТХ-ын ажлын үр нөлөөг дээшлүүлэх чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Бүсийн аймгуудын хурлын ажлын алба 14-22 орон тоотойгоор ажиллаж байхад манай ИТХ 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгааг нэмэгдүүлэх, хурлын дарга жилд зарцуулах тусгайлсан нөөц төсөвтэй, төлөөлөгчдийг чадавхжуулах, гадаад дотоодод туршлага судлуулах ажлын зардалтай байхаар аймгийн ИТХ-ын төсөв, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, сумын ИТХ-ын дарга автомашинтай байх, сумын ИТХ-ын ажлын албыг 2-3 орон тоотой болгох, тэргүүлэгчдийг урамшуулалтай, төлөөлөгчдийг үйл ажиллагааны зардалтай болгох шаардлагатайг олон жил уламжилж байгааг хэрэгжүүлж холбогдох хууль эрх зүйн орчинг бүрдүүлж ажил хэрэг болгох шаардлагатайг уламжилж байна.

	Нарийн бичгийн дарга	/Х.Дашзэвэг/
Танилцсан :	Увс аймгийн ИТХ-ын дарга	/Э.Насанбат /